Улсын бүртгэлийн дугаар

........................................

Нууцын зэрэглэл: Б

Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар: ШуГх/ОХУ/-2017/15

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**

# СҮСЭГТНҮҮД БА ЛАМ НАР: ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ОРОС, МОНГОЛЫН ШИЛЖИЛТИЙН НИЙГЭМ ДЭХ БУДДЫН ҮЗЭЛ САНАА БА ПРАКТИК

**Гадаадтай хамтарсан төслийн тайлан**

**2017-2019 он**


**Төслийн хавсран гүйцэтгэгч:** **ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Буддын судлалын хүрээлэн**

**Төслийн удирдагчид:** **Монголын талаас: С.Цэдэндамба, доктор (Ph.D), профессор,**
**tsedensamdan@yahoo.com, 99047443**

**ОХУ-ын талаас: Л.Л. Абаева, доктор (Sc.D), профессор,**
**ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын**
**Монгол, Төвөд, Буддын судлалын хүрээлэнгийн**
**Философи, соёл ба шашин судлалын салбарын**
**тэргүүлэх эрдэм шинжилгээний ажилтан**



**Санхүүжүүлэгч байгууллага:** **Шинжлэх ухаан технологийн сан**

**Захиалагч байгууллага:** **Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам**

**Тайлан өмчлөгч:** **ШУА-ийн Философийн хүрээлэн**

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**

**ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**


Төслийн удирдагч: Доктор (Ph.D), профессор С.Цэдэндамба

Гүйцэтгэгчид: Доктор (Ph.D) Ц.Цэцэнбилэг

Доктор (Ph.D) Ж.Алтайбаатар

Докторант Б.Мөнхцацралт

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баруун Сэлбийн гудамж-15, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 2 дугаар байр, Философийн хүрээлэн

Утас: 976-330847

Факс: 976-11-330846

Э-шуудан: tsedensamdan@yahoo.com

# ГАРЧИГ


РЕФЕРАТ ... 4
НЭГ. ХАМТАРСАН ТӨСЛИЙН ТУХАЙ ... 5
1.1. Хамтарсан төслийн хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл ... 5
1.2. Судалгааны зорилго ... 5
1.3. Судалгааны хугацаа ... 6
1.4. Судалгааны үе шат, зохион байгуулалт ... 6
1.5. Судалгааны объект, түүвэр ... 6
1.6. Судалгаанд хэрэглэсэн аргууд ... 6
1.7. Мэдээлэл боловсруулах арга ... 7
1.8. Судалгааны ажлын үр дүн, ашиглах боломж ... 7
1.9. Судалгааны баг, зохион байгуулалт ... 7
1.10. Төслийн үр дүнгийн даалгаварын гүйцэтгэл ... 8
ХОЁР. ХАМТАРСАН ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТОЙМ ... 9
2.1. Судалгааны аргазүй, үзэл баримтлал, эмпирик мэдээллийн өгөгдөл, социологийн судалгааны мэдээлэл ... 9
2.1.1. Судалгааны арга зүй, аргачлал боловсруулах, анкет хэрэглэгдэхүүн бэлтгэх – 100% ... 9
2.1.2. Экспертийн судалгаа мэдээлэл авах – 100% ... 9
2.1.3. Архив, албан байгууллагаас мэдээлэл цуглуулах – 100% ... 9
2.1.4. Лам санваартан нартай хийх ярилцлага, сурвалжлага. Антропологийн ажиглалтын мэдээлэл цуглуулна. Экспертүүдийн ярилцлагын мэдээлэл цуглуулна. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх– 100% ... 10
2.1.5. Хот хөдөөгийн сүм хийдийн үйл ажиллагаанд ажиглалт судалгаа хийх. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэлд шилжүүлэх– 100% ... 10
2.1.6. Социологийн судалгаа ба илтгэл – 100% ... 11
2.2. Орос, Монголын хамтарсан эрдэм шинжилгээний хурал, семинар, семпозиум, дугуй ширээний ярилцлага ... 11
2.2.1. “Монгол, Орос дахь буддизмын үзэл санаа” сэдэвт олон улсын дугуй ширээний хэлэлцүүлэг ... 11
2.2.2. Монгол дахь буддын судлал ба нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудалд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал ... 17
2.2.3. “Монгол дахь Гарма Гаржүд ёсны уламжлал” сэдэвт ОУ-ын эрдэм шинжилгээний бага хурал, 2017.07.17, Улаанбаатар ... 20
2.2.4. “Миряне и ламы: буддийские идеи и практики в трансформирующихся обществах России и Монголии” ОУ-ын семинар, 2017.09.20, Улаан-Үд ... 21
2.2.5. “Буддийские идеи и практики в россии и монголии-II” программа международного круглого стола ... 21
2.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл ... 23
2.4. Эрдэм шинжилгээний илтгэл ... 25
2.5. Хамтын бүтээл - «Миряне и ламы: буддийские идеи и практики в трансформирующихся обществах России и Монголии» (Хронологические рамки монографии: конец 20-го-начало 21-го веков) ... 27
ДҮГНЭЛТ ... 29

# РЕФЕРАТ

"Сүсэгтнүүд ба лам нар: өөрчлөгдөж буй Орос, Монголын шилжилтийн нийгэм дэх буддын үзэл санаа ба практик" хамтарсан төслийг 2017-2019 онд ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Шашин судлалын салбар, ОХУ-тай хамтран гүйцэтгэсэн болно.

Тус хамтарсан төсөл нь Буддын шашны нийгэмлэгүүд, тэдгээрийн нийгмийн зохион байгуулалтын хэлбэрийн өөрчлөлтийн өнөөгийн үйл явц, Буддын нийгмийн практикийн үзэл санааны орчин үеийн онцлогийг илрүүлэхэд чиглэсэн.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх нь өөрчлөгдөн буй Орос, Монголын нийгмийн институци дэх буддын шашны бүлгүүдийн (лам нарын болон сүсэгтнүүдийн ) дасан зохицож буй үйл явцын тухай эмпирик мэдээлэлтэй болно. Орос болон Монголын буддизмын ижил төстэй талуудын харьцуулсан судалгаа нь эдгээр орнууд дахь буддын шашны янз бүрийн хэв шинж бүхий бүлгүүдийн (үндэстний ба даяаршлагдсан, сүсэгтний болон сүм хийдийн, хөдөөний болон хотын гэх мэт) хөгжлийн талаарх шинэ мэдээлэл бий болсон.

Хамтарсан төслийн хүрээнд ОХУ болон Монгол Улсад **2** удаагийн эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, нийт **4** олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцов. Мөн багийн гишүүд олон улсын **4** эрдэм шинжилгээний хуралд оролцож эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн болно.

Хамтарсан төслийн багийн гишүүд The Europcan Procecedings of Social&Behavioural Sciences ISSN:2357-1330 дугаартай сэтгүүлд "BUDDHISM IN RUSSIA AND MONGOLIA: PROBLEMS OF COMPARATIVE SOCIOLOGICAL RESEARCH" (L.L. Abaeva, T.B. Badmatsyrenov, S.Z. Galsanova, S.Tsedendamba, Ts. Tsetsenbileg) сэдэвт өгүүллийг нийтлүүлсэнээс гадна 10 гаруй эрдэм шинжилгээний өгүүллийг олон улсын болон дотоодын сэтгүүлд нийтлүүлээд байна.

Мөн хамтарсан төслийн үр дүнгээр "«Миряне и ламы: буддийские идеи и практики в трансформирующихся обществах России и Монголии» (Хронологические рамки монографии: конец 20-го-начало 21-го веков)" сэдэвт хамтын бүтээлийг хэвлүүлж, уншигчдын хүртээл болгоод байна.

# НЭГ. ХАМТАРСАН ТӨСЛИЙН ТУХАЙ

## 1.1. Хамтарсан төслийн хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл

“Сүсэгтнүүд ба лам нар: өөрчлөгдөж буй Орос, Монголын шилжилтийн нийгэм дэх буддын үзэл санаа ба практик” хамтарсан төслийг 2017-2019 онд гүйцэтгэсэн болно.

Тус хамтарсан төсөл нь Буддын шашны нийгэмлэгүүд, тэдгээрийн нийгмийн зохион байгуулалтын хэлбэрийн өөрчлөлтийн өнөөгийн үйл явц, Буддын нийгмийн практикийн үзэл санааны орчин үеийн онцлогийг илрүүлэхэд чиглэж байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх нь өөрчлөгдөн буй Орос, Монголын нийгмийн институци дэх буддын шашны бүлгүүдийн (лам нарын болон сүсэгтнүүдийн ) дасан зохицож буй үйл явцын тухай эмпирик мэдээлэлтэй болно. Орос болон Монголын буддизмын ижил төстэй талуудын харьцуулсан судалгаа нь эдгээр орнууд дахь буддын шашны янз бүрийн хэв шинж бүхий бүлгүүдийн (үндэстний ба даяаршлагдсан, сүсэгтний болон сүм хийдийн, хөдөөний болон хотын гэх мэт) хөгжлийн талаарх шинэ мэдээлэлтэй болно.

Судалгааны үр дүнд судалгааны асуудлаар сүсэгтэнтэй хийсэн ярилцлага, экспертийн үнэлгээ, эрх зүйн баримт бичгийн шинжилгээ, Орос болон Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хийх шинжилгээ зэргийг багтаасан эмпирик мэдээллийн сан бүрдүүлж, хамтын нэг сэдэвт бүтээл, сургалтын гарын авлага болон эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлнэ.

## 1.2. Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь Орос ба Монголын нийгмийн шилжилтийн нөхцөл дэх шашны зүтгэлтнүүдийн (лам хувраг) болон энгийн сүсэгтний бүлгүүдийн хөгжлийн онцлогийг илрүүлэхэд оршино. Дараах зорилтуудыг дэвшүүлсэн:

- Орчин үеийн буддын шашны нийгмийн бүлгүүдийн хэв шинжийг тодорхойлох
- Буддын нийгмийн бүлгүүдийн зохион байгуулалтын хэлбэрийн өөрчлөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлах
- Янз бүрийн хэв шинжийн буддын нийгмийн бүлгүүдийн шашны үйл ажиллагааны үзэл санааны агуулгын онцлогийг илрүүлэх
- Шашны үйл ажиллагаа, түүний нийгмийн үүргийг тодорхойлох зэрэг болно.

### 1.3. Судалгааны хугацаа

Хамтарсан төслийн судалгааг 2017 оны 8 дугаар сарын 15-аас 2019 оны 12 дугаар сарын 31-ний хооронд гүйцэтгэж үр дүнг тайлагнав.

### 1.4. Судалгааны үе шат, зохион байгуулалт

Судалгааг календарчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв. 2017 оны ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу судалгааны арга зүй, аргачлал боловсруулж, анкет хэрэглэгдэхүүн бэлтгэж, экспертийн судалгаа мэдээлэл цуглуулав. Архив , албан байгууллагаас мэдээлэл авч, ажиглалт судалгаа хийв. ОХУ-д болосн эрдэм шинжилгээний бага хуралд оролцов. Монгол дахь буддын шашны нөхцөл байдал, өөрчлөлтийн талаар бичиг баримтын судалгаа хийж, статистик өгөгдлүүдийг цуглуулсан. Анкетийн судалгааны өгөгдлийг цуглуулахдаа оросын талын судлаачидтай хамтран нэг ижил арга зүйгээр монголын нөхцөлд тохируулан боловсруулсан хэрэглэгдэхүүнийг ашигласан нь хоёр улсад хийсэн судалгааны үр дүнг харьцуулахад чиглэж байв.

2018 оны ажлын календарчилсан төлөвлөгөөнд тусгасны дагуу Орос, монголын хамтарсан эрдэм шинжилгээний семинар зохион байгуулах, судалгааны завсрын болон эцсийн үр дүнгүүдээр эрдэм шинжилгээний хурлын илтгэл хэлэлцүүлэх, өгүүлэл хэвлүүлэх ажлуудыг зохион байгуулсан.

2019 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу нэг сэдэвт хамтын бүтээлийн бүлэг, зүйлийн гар бичмэл, эхийг бэлтгэх, редакцид шилжүүлэх, эцэслэх, хэвлүүлэх ажлуудыг гүйцэтгэв. Төслийн тайланг бэлтгэх, хэлэлцүүлэх ажлыг тус тус гүйцэтгэв.

### 1.5. Судалгааны объект, түүвэр

Судалгаанд Улаанбаатар хотын буддын шашны сүм хийдүүд дэх сүсэгтнүүд, лам хувраг 300 хүнээс анкетийн аргаар мэдээлэл цуглуулсан.

### 1.6. Судалгаанд хэрэглэсэн аргууд

Судалгаанд дараах аргуудыг ашигласан:

- Орос, Монгол дахь буддизмын хөгжлийн нийгэм-шашны үйл явцын ерөнхий болон ялгаатай шинж чанарыг харьцуулах харьцуулалтын арга;
- Орос болон Монголын буддизмын түүхэн хөгжлийг тайлбарлах загварчлалын арга;
- Орос болон Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет дахь эх сурвалж, мэдээ, мэдээлэлд шинжилгээ хийх дискурс-анализийн арга;
- Асуулгын арга зэрэг болно.

### 1.7. Мэдээлэл боловсруулах арга

Асуулгын аргаар цуглуулсан тоон мэдээллийг SPSS программд оруулж, статистик шинжилгээ хийв. Үүний тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

1. Цуглуулсан мэдээллийг шалгаж шаардлага хангасан анкетуудыг кодолж мэдээлэл оруулахад бэлтгэв.
2. Мэдээлэл оруулах загварыг SPSS програм дээр бэлтгэж, тоон утгуудыг шивж оруулав.
3. Програмд оруулсан мэдээллийг шалгаж, боловсруулалт хийхэд бэлтгэв.
4. Мэдээлэлд анхан шатны боловсруулалт, бүлэглэлт хийж зарим үзүүлэлтүүдийн хүрээнд хэмжигдэхүүний дундаж, дисперс, корреляцийн хамаарлыг тодорхойлох зэрэг нарийвчилсан шинжилгээ хийв.

### 1.8. Судалгааны ажлын үр дүн, ашиглах боломж

Анкетийн асуулга болон дискурс анализийн үр дүнг оролцуулсан эмпирик өгөгдлүүдийн мэдээллийн сан бүрдсэнээс гадна судалгааны завсрын болон эцсийн үр дүнгээр Орос, Монголын хамтарсан судалгааны арга зүй, эрдэм шинжилгээний семинар 3 удаа зохион байгуулж, эрдэм шинжилгээний илтгэл 11-ийг хэлэлцүүлэн, 4 өгүүлэл, “Буддизм и социорелигиозные процессы в России и Монголии“ (отв. ред. Т.Б.Бадмацыренов. - Улан-Үдэ: Издательство Бурятского госуниверситета, 2016) нэг сэдэвт хамтын бүтээл тус тус хэвлүүлэв.

Судалгааны явцад олж авсан үр дүнг Орос болон Монголын шашны талаарх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон төрийн бус бусад байгууллагад зөвлөмж болгон ашиглах боломжтой. Мөн судалгааны үр дүнд олж авсан онолын болон эмпирик мэдлэгт тулгуурлан их, дээд сургуулиудад гарын авлага, сургалтын авлага, эрдэмтэн судлаачдын судалгааны эх сурвалж, үндсэн мэдээлэл болгон ашиглах боломжтой.

### 1.9. Судалгааны баг, зохион байгуулалт

Хамтарсан төслийн Оросын талын удирдагчаар доктор, профессор Абаева Любовь Лубсановна (главный научный сотрудник, Федеральное государственное бюджетное учреждение науки Институт монголоведения, буддологии и тибетологии Сибирского отделения Российской академии наук (ИМБТ СО РАН)), Монголын талын удирдагчаар Философийн хүрээлэнгийн Шашин судлалын салбарын эрхлэгч, доктор, профессор С.Цэдэндамба нар ажиллаж, Монголын талын гүйцэтгэгчээр Философийн хүрээлэнгийн Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын эрхлэгч ЭШТА, доктор Ц.Цэцэнбилэг, доктор Ж.Алтайбаатар, Шашин судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Б.Мөнхцацралт нар ажиллав.

## 1.10. Төслийн үр дүнгийн даалгаварын гүйцэтгэл

**Техникийн даалгавар**

| д/д | Төслөөр бий болох үр дүн | Төлөвлөсөн | Гүйцэтгэсэн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Судалгааны аргазүй, үзэл баримтлал, эмпирек мэдээллийн өгөгдөл, социологийн судалгааны мэдээлэл | 1 | Судалгааны анкет хэрэглэгдэхүүн болон өгөгдлийн сан | Биелсэн |
| 2. | Орос Монголын хамтарсан эрдэм шинжилгээний хурал, семинар, семпозиум, дугуй ширээний ярилцлага | 2 | Судалгааны аргазүй аргачлал, тайлан мэдээлэл, явцын үр дүн, бүтээгдэхүүн | Биелсэн |
| 3. | Эрдэм шинжилгээний өгүүлэл | 5 | 18 | Биелсэн |
| 4. | Эрдэм шинжилгээний илтгэл | 4 | 19 | Биелсэн |
| 5. | Хамтын бүтээл (эмхэтгэл) Сургалтын гарын авлага | 2 | Хамтын бүтээл | Биелсэн |
| 6. | Судалгааны ажлын эрдэм шинжилгээний тайлан | 1 | Эцсийн тайлан болон өгүүлэл, илтгэл, судалгааны ажлын бүтээгдэхүүнүүдийг хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. | Биелсэн |

# ХОЁР. ХАМТАРСАН ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ТОЙМ

"Гадаадтай хамтарсан төсөл гүйцэтгэх, санхүүжүүлэх" тухай 2018 оны ШуГх//ОХУ/-2017/15 дугаар гэрээний 2 дугаар хавсралт дахь "Төслийн үр дүнгийн даалгавар"-ын дагуу 2017-2019 оны үр дүнгийн тайланг тайлагнаж байна.

## 2.1. Судалгааны аргазүй, үзэл баримтлал, эмпирик мэдээллийн өгөгдөл, социологийн судалгааны мэдээлэл

### *2.1.1. Судалгааны арга зүй, аргачлал боловсруулах, анкет хэрэглэгдэхүүн бэлтгэх – 100%*

Судалгааны баг тухайн асуудлаар судалгаа хийх хөтөлбөр, зорилт, шийдвэрлэх асуудлаа нарийвчилан боловсруулан томъёолж, судалгааны мэдээлэл авах анкет хэрэглэгдэхүүний эхний хувилбарыг бэлтгэсэн.

Хамтарсан төслийн хүрээнд ОХУ-ын талын судлаачидтай хамтран нэгэн ижил судалгааны арга зүй, аргачлалыг тус тусын орны онцлог нөхцөл байдалтай уялдуулж зарим нэмэлт асуултаар баяжуулан, буддын шашин шүтлэгийн хүрээнд гарч буй өөрчлөлт, өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлагыг тандан судалж тодруулах, харьцуулалт хийхийг зорьсон. Монголын талын судлаачид Улаанбаатар хотоос мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэв.

300 гаруй хариултын хувилбартай 40 асуулт бүхий 6 нүүр (хуудас) асуулга судалгааны анкетийг боловсруулж судалгаанд хэрэглэсэн. (ХАВСРАЛТ 1)

### *2.1.2. Экспертийн судалгаа мэдээлэл авах – 100%*

Судалгаанд хамрагдах экспертийн бүлгийг тодорхойлж, Улаанбаатар хот болон Улаан-Үд хотод зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний семинар, бага хуралд оролцсон орос экспертүүдтэй уулзалт ярилцлага хийв.

### *2.1.3. Архив, албан байгууллагаас мэдээлэл цуглуулах – 100%*

Хамтарсан төслийн хүрээнд холбогдох газруудаас статистик мэдээ материал цуглуулах, судалгаа явуулахад онол арга зүйн суурь болох бүтээлүүдтэй танилцах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Үүнд: Дараах баримт бичгүүдээр сан бүрдүүлж судалгаанд ашиглав. Үүнд:

1. Монгол Улсын дахь шашин шүтлэгийн төлөв байдалд холбогдох өмнө хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайлан, өгөгдөлүүд – 3 судалгаа;
2. Үндэсний статистикийн хорооны статистик өгөгдөлүүд – 1994-2016 оны тоо баримтууд;

3. Шашин, сүм хийдийн талаар холбогдох төрийн байгууллагуудаас гаргасан мэдээ, тайлан, судалгааны бусад эх сурвалжууд – 2 судалгаа;
4. Иргэдийн шашин шүтлэг, сүсэг бишрэлийн талаар олон улсын байгууллагуудын дүгнэлт, тайлан мэдээ – 10 тайлан;
5. Шашны талаар төрөөс баримтлах бодлого, төр сүм хийдийн харилцаанд холбогдох бодлогын болон эрх зүйн баримт бичгүүд, холбогдох журам, тогтоол, шийдвэр – 20 баримт бичиг;

Мөн Монголын шашны амьдралд гарч буй олон талт өөрчлөлт, тэдгээрийн өнөөгийн ба хэтийн үр дагавар, хүмүүсийн шашинд хандах хандлагын олон талт байдал, шашин хоорондын болон шашны дотоод харилцааны зөрчил, зохицол, төр шашны харилцааны бодлого, хэрэгжилт; өнөөгийн нөхцөлд шашин шүтлэгийн байдал, шашин шүтэх эрх, эрх чөлөөний тухай ойлголт, хэрэгжилт, асуудал, зөрчил; монгол дахь ислам шашны түүх, өнөөгийн байдал; буддын философийн олон урсгалуудын онол сургаал дахь үнэ цэнэтэй, хүн төрөлхтний нийтлэг ач холбогдолтой үзэл санаануудыг тодотгон гаргаж, өнөө үед түүнээс суралцахын ач холбогдлыг судалсан монголын эрдэмтэдийн бүтээлүүдийг судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

### *2.1.4. Лам санваартан нартай хийх ярилцлага, сурвалжлага. Антропологийн ажиглалтын мэдээлэл цуглуулна. Экспертүүдийн ярилцлагын мэдээлэл цуглуулна. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх– 100%*

Судалгааны баг лам санваартантай ярилцлага хийж, тухайн асуудлаар судалгаа хийх хөтөлбөр, зорилт, шийдвэрлэх асуудлаа нарийвчилан гаргаж ярилцлага, сурвалжлага хийсэн судалгааныхаа үр дүнд суурилсан эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, The Europcan Procecedings of Social&Behavioural Sciences ISSN:2357-1330 дугаартай сэтгүүлд “BUDDHISM IN RUSSIA AND MONGOLIA: PROBLEMS OF COMPARATIVE SOCIOLOGICAL RESEARCH” (L.L. Abaeva, T.B. Badmatsyrenov, S.Z. Galsanova, S.Tsedendamba, Ts. Tsetsenbileg) сэдэвт өгүүллийг нийтлүүлсэн болно.

### *2.1.5. Хот хөдөөгийн сүм хийдийн үйл ажиллагаанд ажиглалт судалгаа хийх. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэлд шилжүүлэх– 100%*

Судалгааны баг хот хөдөөгийн сүм хийдийн үйл ажиллагаанд ажиглалт судалгаа хийж, мэдээлэл цуглуулав.

### *2.1.6. Социологийн судалгаа ба илтгэл – 100%*

Төслийн багийн гишүүд антропологи ажиглалтын мэдээлэл, бусад судалгааны эх сурвалж дээр ажилласан судалгааны үр дүнд олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд 2 илтгэл хэлэлцүүлсэн болно.

Монголын буддист эмэгтэйчүүдийн "Буман ханд" холбоо, МУИС-ийн Философи, Шашин судлалын тэнхим, Монголын шашин судлаачдын холбоо, Монголын Төвөд судлалын холбоо 2018 оны 10 сарын 31, 11 сарын 1-нд хамтран зохион байгуулсан "Буддизм ба тогтвортой хөгжил" олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд төслийн удирдагч С.Цэдэндамба "Буддизм тогтвортой хөгжлийн үндэс болох нь" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн болно.

СУИС-аас зохион байгуусан "Монголчуудын соёлын ертөнц: өв, үнэт зүйл, урлаг" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд төслийн удирдагч доктор С.Цэдэндамба "Буддизм монголчуудын соёлын амьдралд: өнгөрсөн ба өнөө үе" сэдэвт илтгэл, төслийн багийн гишүүн Л.Л Абаева "Нүүдлийн соёл, амьдарлын хэв маягийн нөхцөл дэх Монголчуудын оюун санааны өв" сэдэвт илтгэлийг тус тус тавьж хэлэлцүүлж хэвлүүлсэн болно.

## 2.2. Орос, Монголын хамтарсан эрдэм шинжилгээний хурал, семинар, семпозиум, дугуй ширээний ярилцлага

Хамтарсан төслийн хүрээнд ОХУ болон Монгол Улсад **2** удаагийн эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, нийт **4** олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцов. Мөн багийн гишүүд олон улсын **4** эрдэм шинжилгээний хуралд оролцож илтгэл хэлэлцүүлсэн болно.

### *2.2.1. "Монгол, Орос дахь буддизмын үзэл санаа" сэдэвт олон улсын дугуй ширээний хэлэлцүүлэг*

"Сүсэгтнүүд ба лам нар: өөрчлөгдөж буй орос, монголын нийгэм дэх буддын шашны үзэл санаа ба практик" (ШуГх/ОХУ/-2017/15 дугаар) гадаадтай хамтарсан төслийн хүрээнд "Монгол, Орос дахь буддизмын үзэл санаа" сэдэвт олон улсын хэлэлцүүлгийг 2019 оны 05 сарын 03-ны өдөр "Зүүн хүрээ" Дашчойлин хийдийн хурлын танхимд зохион байгуулав.

Хэлэлцүүлгийн ерөнхий зохион байгуулагчаар ШУА-ийн Философийн хүрээлэн, Шашин судлалын салбар ажиллаж, Оросын ШУА-ийн Монгол, Төвд, Буддын судлалын хүрээлэн, "Зүүн хүрээ" Дашчойлин хийд хамтарч ажиллалаа.

Хэлэлцүүлэгт Оросын ШУА-ийн Монгол, Төвд, Буддын судлалын хүрээлэнгийн эрдэмтэн доктор (Sc.D), профессор Л.Л. Абаева, доктор (Ph.D) М.В. Аюшеева, доктор

(Ph.D) П.В.Варнавский,  доктор (Ph.D) А.А. Базаров, доктор (Ph.D) С.С. Цыпилова нар хүрэлцэж ирж илтгэл хэлэлцүүлсэн. Мөн “Зүүн хүрээ” Дашчойлин хийдийн судлаач, лам нар, Зүүн хүрээ коллежийн захирал Ц.Мөнх-Эрдэнэ, Бурхан шашин соёл судлалын хүрээлэнгийн захирал Г.Мягмарсүрэн, бусад судлаачид сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүллээ. Мөн БНХАУ-ын Найралт найрамдах хийдийн лам, МУИС-ийн докторант С.Сумьяа, МУИС-ийн докторант Б.Жамьян нар сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүллээ.

Хэлэлцүүлэг нь зөвхөн Орос, Монголын хамтарсан төслийн хүрээгээр оролцогчид нь хязгаарлагдсангүй, “Зүүн хүрээ” Дашчойлин хийдийн лам нар, БНХАУ-ын ӨМӨЗО-оос оролцогчид оролцсон, өргөн хүрээтэй, олон сэвдийг хамарсан хэлэлцүүлэг болж өрнөснөөрөө онцлогтой боллоо. Хэлэлцүүлэгт “Зүүн хүрээ” Дашчойлин хийдийн тамгын лам Ц.Алтанхүү “Сүм хийдийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийг (IT) ашиглах нь” илтгэлдээ орчин үеийн IT техник технологийг хэрхэн ашиглаж байгаа, цаашид хэрхэн өргөжүүлэх талаар, мөн IT технологийг ашиглаж сүсэгтэн хэрхэн хурал номын уншлагаа захиалах, цаг хугацаа хэмнэж байгаа тухай сонирхолтой илтгэл хэлэлцүүллээ. Зүүн хүрээ коллежийн захирал Ц.Мөнх-Эрдэнэ коллежийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээний ажлаа танилцуулсан болно. Илтгэгч Б.Идэрбаяр “VIII богд Жавзандамба хутагтын сүмбум зохиолын тойм” илтгэлдээ VIII богд Жавзандамба хутагтын сүмбум зохиолыг тоймлон өгүүлэхийн зэрэгцээ өөрийн шинэ бүтээлээ танилцууллаа. Мөн тэрээр судалгаа шинжилгээний ажилдаа нэр томьёо, орчуулгын үгийг оновчтой авч хэрэглэх тухай санаагаа мөн илэрхийлсэн болно. Илтгэгч М.Эрдэнэбилэг “Уламжлалт тосон урлал ба Намсрайн орны байгууламж” илтгэлдээ ямааны бөөрний өөхөөр Намсрай бурханы орныг бүтээсэн тухайгаа танилцуулсан болно. Тус бүтээл нь “Зүүн хүрээ” Дашчойлин хийдэд хадгалагдаж байна. Энэ мэтчилэн илтгэгчид маань цаг үеийн шинжтэй асуудлаар болон буддын шашны түүх, уламжлал, эх сурвалжын тухай сонирхолтой илтгэл хэлэлцүүлсэн ач холбогдолтой хэлэлцүүлэг болж өрнөлөө.

“МОНГОЛ, ОРОС ДАХЬ БУДДИЗМЫН ҮЗЭЛ САНАА БА ЗАН ҮЙЛ”

## ОЛОН УЛСЫН ДУГУЙ ШИРЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ[1]

Хэзээ: 2019 оны 05 дугаар сарын 03
Хаана: "Зүүн Хүрээ" Дашчойлин хийд

## ХӨТӨЛБӨР

Хурлыг удирдагч: доктор, профессор С.Цэдэндамба

| | |
|---|---|
| **$13^{40} – 13^{50}$** | **Бүртгэл** |
| | **Нээлт** |
| **$13^{50} – 14^{00}$** | **С.Цэдэндамба**- “Сүсэгтнүүд ба лам нар: өөрчлөгдөж буй Орос, Монголын нийгэм дэх буддын үзэл санаа ба практик” хамтарсан төслийн удирдагч, ШУА-ийн ФХ-ийн шашин судлалын салбарын эрхлэгч, доктор, профессор<br>**Ч.Дамбажав**- "Зүүн хүрээ" Дашчойлин хийдийн тэргүүн хамба, доктор, профессор |
| **$14^{00} – 14^{10}$** | **Л.Л. Абаева.** “Буддисты-миряне в контексте идей и практик буддийского Канона”. – г.н.с. Отдела философии, культурологии и религиоведения ИМБТ СО РАН.- профессор, д.и.н. |
| **$14^{00} – 14^{10}$** | **Г.Мягмарсүрэн.** “Монгол мэргэдийн зохиол бүтээл ба “Мангала питака” цуврал”.- Бурхан шашин соёл судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D) |
| **$14^{10} – 14^{20}$** | **Ц.Мөнх-эрдэнэ.** “Зүүн хүрээ коллежийн сургалтын тойм”.-<br>Зүүн хүрээ коллежийн захирал , докторант |

---

[1] *“Сүсэгтнүүд ба лам нар: өөрчлөгдөж буй орос, монголын нийгэм дэх буддын шашны үзэл санаа ба практик” ОХУ-ийн ШУХС, БСШУСЯ нарын  хамтарсан төслийн хүрээнд зохион байгуулагдсан. (Шугх/ОХУ/-2017/15 дугаар)*

**$14^{20} – 14^{30}$** **Ц.Алтанхүү.** “Сүм хийдийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийг (IT) ашиглах нь”.- (Зүүн хүрээ Дашчойлин хийдийн жишээн дээр), магистр

**$14^{30} – 14^{40}$** **М.В. Аюшеева** "Миряне и ламы: исторический опыт взаимодействия по архивным материалам ЦВРК ИМБТ СО РАН".- н.с Центра восточных рукописей и ксилографов ИМБТ СО РАН, к.и.н.

**$14^{40} – 14^{50}$** **Б.Идэрбаяр.** “VIII богд Жавзандамба хутагтын сүмбум зохиолын тойм”.- докторант

**$14^{50} – 15^{00}$** **Н.Мөнхцэцэг.** “Буддын гүн ухаанд оюун ухааныг авч үзэх нь”,-

МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн докторант

**$15^{00} – 15^{10}$** **Ц.Цэцэнбилэг.**“Буддизмын уламжлалт үнэлэмж”.-

ШУА-ийн ФХ-ийн Социологи, нийгмийн сэтгэлзүйн салбарын эрхлэгч, доктор (Ph.D)

**$15^{10} – 15^{20}$** **Ж.Алтайбаатар** “Бурханы шашны олон нийтийн байгууллага”.-

ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн, докторант

**$15^{20} – 15^{30}$** **Б.Мөнхцацралт.** “Чин сүзэгт номун хан Лувсанноровшийравын нэгэн зохиолын тухайд”.- ШУА-ийн ФХ-ийн Шашин судлалын салбарын ЭША, магистр

**$15^{30} – 15^{40}$** **С.Янжинсүрэн.** МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D), профессор,

**С.Сумьяа.** МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн докторант

“Найралт найрамдах хийдийн үйл ажиллагааны тухай”

**$15^{40} – 15^{50}$** **Цайны завсарлага**

**$15^{50} – 16^{00}$** **П. В.Варнавский. “**Ислам как социокультурный механизм интеграции среднеазиатских мигрантов и формирование мусульманской общины Улан-Удэ в постсоветский период". –н.с. Отдела истории, этнологии и социологии ИМБТ СО РАН, к.и.н.

**$16^{00} – 16^{10}$** **А.А. Базаров, С.С. Цыпилова. “** Коллекция предметов буддийского изобразительного искусства (танка) ЦВРК ИМБТ СО РАН, как объект изучения буддийских визуальных практик”. –в.н.с. Центра восточных рукописей и ксилографов ИМБТ СО РАН, д.филос.н.; н.с. Центра

восточных рукописей и ксилографов ИМБТ СО РАН.

$16^{10}$ – $16^{20}$ **И.Ядамсүрэн.** “Төвд Монголын шашин соёлын харилцааг судлах асуудалд” (“Зүүн хүрээ” Дашчойлин хийдийн жишээн дээр). -докторант

$16^{20}$ – $16^{30}$ **М.Нандинбаатар.** “Зүүн гүний хүрээ Шаддүвдаржаалин хийдийн тухай”. -магистр

$16^{30}$ – $16^{40}$ **П.Батбаатар.** “Зуурдын хавцгайгаас гэтэлгэгч баатар хэмээх шаштирын бүтэц агуулгын шинжилгээ”. -магистрант

$16^{40}$ – $16^{50}$ **М.Эрдэнэбилэг.** “Уламжлалт тосон урлал ба Намсрайн орны байгууламж”. -магистрант

$16^{50}$ – $17^{00}$ **Б.Жамьян** “Олонхи бурхад” судрын харьцуулсан шинжилгээ: эх бичиг судлалын үүднээс авч үзэх нь”

$17^{00}$ – $17^{40}$ **Асуулт хариулт, хэлэлцүүлэг**

$17^{40}$ – $18^{00}$ **Хаалт**

## ХАНЫН ИЛТГЭЛҮҮД

**Актамов И.Г**. « Буддийское образование в Бурятии: история и современность». – канд.пед.наук, Зав. Центром переводов с восточных языков ИМБТ СО РАН.

**Бадмацыренов Т.Б**. «Социальная структура сообществ буддистов-мирян Бурятии». - канд.социол.наук, доцент, Бурятский госуниверситет им. Д. Банзарова

**Бадмацыренов Т.Б**. «Социальная структура сообществ буддистов-мирян Бурятии». - канд.социол.наук, доцент, Бурятский госуниверситет им. Д. Банзарова

**Бадараев Д.Д.** «Религиозность сельского населения Бурятии». - канд.социол.наук, доцент, с.н.с. ИМБТ СО РАН.

**Дашибалова Д.В**. «Буддийские мотивы в современной монгольской литературе». - к.ф.н.,в.н.с.. Центра восточных рукописей и ксилографов ИМБТ СО РАН.

**Комбаев А.В**. « Религиозность осужденных в местах лишения свободы». - канд.полит.наук, доцент, зав. каф. политологии и социологии, Бурятский госуниверситет им. Д. Банзарова.

**Сабиров Р.Т.** «Основные формы взаимодействия мирян с буддийскими монастырями в современных России и Монголии». - канд.истор.наук,

доцент, Московский госуниверситет

**Намсараев Д.Ц. , Намсараева В.Ц**. «Возрождение буддийских монастырей в Селенгинском районе Бурятии». – член Союза журналистов. - г.Гусиноозерск.

**Цыренов Ч.С**.”Зерцало мудрости Галшиева и образ мирянина: начало XX века». – к.и.н., н.с. Отдела философии, культурологии и религиоведения ИМБТ СО РАН.

**Абаева А.Т.** «Буддийские термины в бурятском и корейском языках:сопоставительный анализ». – аспирант Одела языкознания ИМБТ СО РАН

**Ододоева Б.В**. «Буддийская живопись Бурятии: XXI век». - аспирант Отдела философии, культурологии и религиоведения ИМБТ СО РАН.

**Родионов В.А**.» Фактор Далай-ламы в монголо-китайских отношениях». - канд.полит.наук, доцент, зав. каф. истории и регионоведения стран Азии, Бурятский госуниверситет им. Д. Банзарова.

**Цыбикова Б-Х. Б** «Мифологические мотивы и символы в устных рассказах бурят Внутренней Монголии». –к.ф.н., в.н.с, доцент Отдела литературоведения и фольклористики ИМБТ СО РАН.

**Ринчинова О.С.,Цыренова Н.Д**. «Новый письменный источник из архива Буручкома по истории тибетской медицины Б-М АССР». – к.и.н., н.с. Центра восточных рукописей и ксилографов ИМБТ СО РАН; м.н.с. Центра переводов с восточных языков ИМБТ СО РАН.

**Васильева И.Г..** "Вклад тибетца Агвана Пунцока в формирование института Хамбо- лам Восточной Сибири (материалы к жизнеописанию).- - практикующий буддист.

**Лощенков А. С.** "Тантра в повседневной практике лам и мирян"».- к.и.н., н.с. Отдела философии, культурологии и религиоведения ИМБТ СО РАН.

**Тушинов Б.Л. «**Сочинение Чахар геше Лобсанг Цультима «Жизнеописание высокочтимого Цзонкапы, изложенное доступным образом» как источник изучения биографии выдающегося буддийского реформатора». - м.н.с. Лаборатории Центра переводов с восточных языков ИМББТ СО РАН

### *2.2.2. Монгол дахь буддын судлал ба нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудалд" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал*

Профессор Г.Лхагвасүрэнгийн мэндэлсний 60 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг ШУА-ийн Философийн хүрээлэн, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим, Удирдлагын академи, "Гүржавын Лхагвасүрэн" сан хамтран "МОНГОЛ ДАХЬ БУДДЫН СУДЛАЛ БА НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ТҮҮХИЙН АСУУДАЛД" сэдвийн дор МУИС-ийн хурлын танхимд 2018 оны 12 сарын 7-ны өдөр зохион байгуулав. Хурлыг ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Г.Чулуунбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулан, МУИС-ийн ШУС-ийн захирал доктор (Ph.D), профессор Г.Эрдэнэбаяр, Удирдлагын академийн захирал доктор (Ph.D), профессор С.Зүльфикар нар нээж үг хэллээ.

Уг эрдэм шинжилгээний бага хурал нь "Монголын буддын судлалд", "Монголчуудын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүх судлалд", "Ноён хутагт Данзанравжаа судлалд", "Сэтгэлийн тухай буддын сургаалын судлалд" гэсэн дөрвөн салбар хуралдааны хүрээнд зохион байгуулагдаж, салбарын нэр хүндтэй эрдэмтэд илтгэлээ танилцуулж бүтээлч хэлэлцүүлэг өрнүүллээ.

**"МОНГОЛ ДАХЬ БУДДЫН СУДЛАЛ БА НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ТҮҮХИЙН АСУУДАЛД" СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ХӨТӨЛБӨР**

9:00-9:30 Бүртгэл

09:30-09:50 Нээлтийн үйл ажиллагаа

- ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Г.Чулуунбаатар
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн соёл, шашны бодлогын эрхэлсэн зөвлөх Ц.Хулан
- МУИС-ын ШУС-ийн захирал доктор (Ph.D), профессор Г.Эрдэнэбаяр
- Удирдлагын академийн захирал доктор (Ph.D), профессор С.Зүльфикар

09:50-10:00 Хуралд оролцогчид дурсгалын зураг авахуулна.

**ӨГЛӨӨНИЙ САЛБАР ХУРАЛДААН-1 "Монголын Буддын судлалын асуудалд"**

Хурал удирдах: Доктор (Ph.D), профессор Б.Дагзмаа

10:00-10:10 Л.Тэрбиш (доктор (Sc.D), профессор, Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн)
***Жанжаа хутагт Ролбийдоржийн төгс зохионгуйн товч***

| | |
|---|---|
| 10:10-10:20 | Б.Жамбал (МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Шашны их сургуулийн багш)<br>***Лувсанжамба нэртийн төвд хэлээр туурвисан зохиол бүтээлийн тухай*** |
| 10:20-10:30 | Д.Бүрнээ (доктор (Ph.D), профессор, МУИС-ийн Монгол хэл-хэл шинжлэлийн багш), Сарангэрэл (БНХАУ)<br>***"Билгийн чанад хүрсэн зуун мянган тоот" судрын нэгэн гар бичмэл эхийн тухай*** |
| 10:30-10:40 | Б.Сайнбилэг (доктор (Ph.D))<br>***Өрнө дахин дахь Монголын буддын судлалын өнөөгийн байдал*** |
| 10:40-11:10 | Хэлэлцүүлэг |
| 11:10-11:30 | Цайны завсарлага |

**ӨГЛӨӨНИЙ САЛБАР ХУРАЛДААН-2 “Монголчуудын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүх судлалд”**

Хурал удирдах: Доктор (Ph.D), профессор М.Гантуяа

| | |
|---|---|
| 11:30-11:40 | С.Янжинсүрэн (Доктор (Ph.D), дэд профессор, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш)<br>Б.Дагзмаа (доктор (Ph.D), профессор, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн эрхлэгч)<br>***Монголын нийгэм улс төрийн сэтгэлгээний түүх интердисциплинар сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага*** |
| 11:40-11:50 | Н.Сарантуяа (доктор (Sc.D), профессор, Стратеги судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан)<br>***Монголын Буддизм хийгээд Монгол төрийн ёс зүй: соёл-иргэншлийн код*** |
| 11:50-12:00 | Ц.Баатартогтох (доктор (Ph.D), профессор, Удирдлагын академийн Засаглалын судалгаа, зөвлөх үйлчилгээний төвийн эрхлэгч)<br>***Буддизмын ёс зүй төрийн албан хаагчийн ёс зүйд нөлөөлсөн тухай асуудалд*** |
| 12:00-12:10 | Б.Оюунбилэг (Баянхошууны хийд)<br>***Монголын шашин, төр хоёр ёсны уламжлал ба орчин үе*** |
| 12:10-12:20 | О.Бумдарь (Өвөр Монголын Их Сургуулийн-Монгол судлалын сургуулийн докторант)<br>***1930-аад оны эхэн үеийн Монгол улсын түүхэнд холбогдох есдүгээр дүрийн Банчин богд*** |
| 12:20-12:40 | Хэлэлцүүлэг |
| 12:40-13:40 | Үдийн цайны завсарлага |

**ҮДЭЭС ХОЙШ САЛБАР ХУРАЛДААН-1 “Ноён хутагт Данзанравжаа судлалд”**

Хурал удирдах: Доктор (Ph.D), дэд профессор С.Янжинсүрэн

| | |
|---|---|
| 13:40-13:50 | Б.Тунгалаг (доктор (Ph.D), профессор, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш) |
| | ***Г.Лхагвасүрэнгийн "Ноён хутагт Данзанравжаа" бүтээл дэх нийгэм-зан суртахууны орчин үеийн ач холбогдол*** |
| 13:50-14:00 | Н.Амгалан (МБШТөв Гандантэгчэнлин хийд, Эрдэм соёлын хүрээлэн) |
| | ***Онгийн голын Ноён хутагт ламтан*** |
| 14:00-14:10 | Б.Дэлгэрмаа (Доктор (Ph.D), дэд профессор, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш) |
| | ***Данзанравжаагийн гоо зүйн үзэл*** |
| 14:10-14:20 | М.Золзаяа (доктор (Ph.D), Соёл, урлаг судлалын хүрээлэн) |
| | ***Архивт хадгалагдаж буй нэгэн судалгааны бүтээлийн эхийн тухай*** |
| 14:20-14:40 | Хэлэлцүүлэг |
| 14:40-15:00 | Цайны завсарлага |

## ҮДЭЭС ХОЙШ САЛБАР ХУРАЛДААН-2 "Сэтгэлийн тухай буддын сургаалын судлалд"

Хурал удирдах: Доктор (Ph.D), профессор С.Цэдэндамба

| | |
|---|---|
| 15:00-15:10 | Т.Булган (доктор (Ph.D), профессор, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш) |
| | ***Буддын Йогачара философийн зарим категоруудыг авч үзэх нь*** |
| 15:10-15:20 | Н.Мөнхцэцэг (МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн докторант, Зүүн Хүрээ Коллеж, Буддын Соёл Судлалын хүрээлэн) |
| | ***Сэтгэл, оюуны төгөлдөршил буддын онолын үндэс болох нь*** |
| 15:20-15:30 | Ж.Энхбаяр (доктор (Ph.D), ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан) |
| | ***Профессор Г.Лхагвасүрэнгийн монголын философи, буддын философийн түүх судлалд оруулсан хувь нэмэр*** |
| 15:30-15:40 | М.Гантуяа (доктор (Ph.D), профессор, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн судлаач, профессор) |
| | ***Сэтгэлийн чанар ба гүн ухааны мэтгэлцээн*** |
| 15:40-16:00 | Хэлэлцүүлэг |
| 16:00-16:30 | Хурлын хаалт |
| | ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор Б.Пүрэвсүрэн |

### *2.2.3. “Монгол дахь Гарма Гаржүд ёсны уламжлал” сэдэвт ОУ-ын эрдэм шинжилгээний бага хурал, 2017.07.17, Улаанбаатар*

ШУА-ийн Философийн хүрээлэн, Оросын Очирт хөлгөний Буддистуудын холбоо хамтран “Монгол дахь Гарма Гаржүд ёсны уламжлал” эрдэм шинжилгээний бага хурлыг 2017 оны 7 дугаар сарын 17-нд ШУА-ын Тэргүүлэгчдийн газрын хурлын танхимд зохион байгуулсан. Уг олон улсын эрдэм шинжилгээний бага хурал нь буддизмын олон зуун жилийн түүхтэй манай улсын хувьд эрдэм шинжилгээ, судалгааны хүрээнд төдийлөн гүнзгийрүүлэн судалж байгаагүй Гарма Гаржүд ёсны монгол дахь түүхэн уламжлал, орчин үеийн асуудлыг анх удаа хөндөж байгаагаараа чухал ач холбогдолтой байв.

Хуралд Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Үндэсний номын сан, Шашин судлаачдын монголын нийгэмлэг, ОХУ-ын ШУА-ын Сибирийн салбарын Монгол судлал, Буддын судлал, Төвд судлалын хүрээлэн, ОХУ-ын Дорно дахины музей, ОХУ-ын Дорно дахины орнуудын институти, Их Британийн Ливерпүүл Жон Мүүрсийн их сургууль, БНХАУ-ын Хейхэ Их Сургууль, Энэтхэгийн Гармавагийн олон улсын буддистуудын институт зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны 10 гаруй байгууллагын 50 гаруй эрдэмтэн судлаачид, буддын шашны зүтгэлтнүүд оролцож дэлхийн болон Монгол дахь буддизмын орчин үеийн асуудал, Дорно дахин, тэр дундаа Монголд Гарма Гаржүд ёс дэлгэрсэн түүх, өнөөгийн байдал, Буддизмын зарим түүхэн сурвалжууд дахь Гарма Гаржүд ёсны үзэл санаа, уламжлал, Буддын бясалгалын аргуудын сэтгэл судлалын судалгааны зарим үр дүн зэрэг илтгэлүүд хэлэлцүүлсэн.

